



163

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар Б/128


Ховд

Б. Энхбадрахыг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн жолоочоор Бадамрайн Энхбадрахыг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн томилсугай.
2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
3. Б.Энхбадрахыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга (Б.Нямдэлгэр)-д үүрэг болгосугай.
4. Б.Энхбадрахыг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ний ТҮ-3 дахь зэрэглэл буюу 569585 төгрөг (таван зуун жаран есөн мянга таван зуун наян тав)-өөр цалин цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувь, ур чадварын нэмэгдлийг тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б. БАЯРСҮХ



Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны
өдрийн Б/128 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Энхмандал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
нягтлан бодогч

Гишүүд: М.Лхагвасүрэн - Санхүү, аж ахуйн тасгийн жолооч

Нарийн бичгийн

дарга: Х.Болормаа - Санхүү, аж ахуйн тасгийн нярав

-оОо-